



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019 02.02 № 05/1142
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийн тухай

Танай 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/49 дүгээр албан бичгээр ирүүлсэн холбогдох материалыг хүлээн авч танилцлаа.

Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 3 дугаар дунд сургуулийн захирлаар томилогдохоор нэр дэвшсэн Лхагвасүрэнгийн Чулуунбаатарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ” гэж заасны дагуу томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлээгүй байх тул хянан үзэх боломжгүй байна.

Цаашид нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас холбогдох материалын хамт ирүүлэхэд анхаарч ажиллана уу.

Хавсралтаар 11 хуудас материал буцаан хүргүүлэв.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



X.ХАШБААТАР

0002104